



ТӨВ АЙМАГ
БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/89

Бүрэн сум

Газар эзэмшүүлэх эрхийн гэрчилгээний
дуудлага худалдааг дахин зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, "Газрын тухай хууль"-ийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам", Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 03 дугаар тогтоолын 01 дүгээр хавсралтаар батлагдсан "Сумын 2023 оны тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөө"-г тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын 2023 оны тухайн жилийн Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдсан дуудлага худалдаагаар эзэмшүүлэх газрын байршил, хэмжээ, зориулалт, анхны үнэ, дэнчингийн үнэ, дуудлага худалдаа зохион байгуулах хугацааг хавсралтаар баталсугай.

2. Газар эзэмшүүлэх дуудлага худалдааг холбогдох хууль, журам төлөвлөлтийн дагуу зохион байгуулахыг Газрын даамал (Б.Батхүү)-д үүрэг даалгасугай.

3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж, ажиллахыг сумын Засаг даргын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Пүрэв-Очир)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т. ТҮВШИНБАТ

413305202



Сумын Засаг даргын 2023 оны .01. дугаар сарын .01.-ны
өдрийн .189..... дугаар захирамжийн хавсралт

Д/д	Төлөвлөлтийн нэгж талбарын дугаар	Байршил	Газрын хэмжээ (м ²)	Зориулалт	Эрхийн төрөл	Эрхийн хугацаа	Дуудлага худалдааны төрөл	Дуудлага худалдааны анхны үнэ (сая.төг)	Дуудлага худалдааны дэнчингийн хэмжээ (сая.төг)
1	2980867	Төхөм 1-р баг	10000	Мал нядалгааны үйлдвэрийн газар	Эзэмших	15	Цахим	4,800,000	480,000
2	3027531	Төхөм 1-р баг	100001	Мод үржүүлгийн газар	Эзэмших	15	Цахим	48,000,480	4,800,048
3	2979767	Төхөм 1-р баг	2079	Жимс, жимсгэний усалгаагүй тариалан	Эзэмших	15	Танхимаар	36,164	3,616
4	2979768	Төхөм 1-р баг	1300	Жимс, жимсгэний усалгаагүй тариалан	Эзэмших	15	Танхимаар	26,614	2,661

-----oOo-----